



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/220

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах чиглэлээр ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, сэтгэл оюунаа дайчлан ажилласан хавсралтанд дурдсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 150000 /нэг зуун тавин мянга/ төгрөгийг баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 150000 төгрөг/ нэг зуун тавин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-1256

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 06-ны өдрийн
А/220 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Мөнгөн дүн
1.	Г.Ариунаа	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Төвлөрсөн ариутгалын тасгийн сувилагч	30000
2.	Б. Дэлгэрсүрэн	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Шинжилгээний тасгийн биохимийн лаборант	30000
3.	Х.Цэцгээ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Үйлчлэгч, туслах сувилагч	30000
4.	Б.Гэрэлмаа	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч	30000
5.	Г.Мягмарсүрэн	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Халдварт өвчин судлалын тасгийн сувилагч	30000
БҮГД				150000

-оОо-